**ОРХОН АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 31 өдөр | Дугаар А/82 | Баян-Өндөр сум

ХАБЭА-н орон тооны бус байнгын зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 27.2 дахь заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулсугай.

2. Орон тооны бус байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн:

Зөвлөлийн дарга: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан

Зөвлөлийн нарийн бичиг: Олон нийттэй харилцах ажилтан

Комиссын гишүүд: Яаралтай гамшгийн үеийн тусламж үйлчилгээ, оношилгоо эмчилгээний технологи хариуцсан мэргэжилтэн

Орчны эрүүл мэнд, нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, байгууллагын үйл ажиллагааны автоматжуулалт, сүлжээ хариуцсан мэргэжилтэн

3. Холбогдох хууль, дүрэм журмыг мөрдөн ажиллахыг комиссын гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.СҮХЭЭ